



MONGOLIAN CASHMERE

**“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Компанийн 2020 оны үйл  
ажиллагааны болон санхүүгийн  
тайландаа өгөх ТУЗ-ийн  
дүгнэлтийг  
батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт,  
Компанийн дүрмийн 6.1.9.10 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн  
2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Төлөөлөн  
Удирдах Зөвлөлөөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцэний үндсэн  
дээр 2021 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын  
Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

Нэг. Говь ХК-ийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд  
Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг Хавсралт 1 ёсоор баталсугай

ХУРЛЫН ДАРГА



Д.ГЭРЭЛМАА

Говь ХК-ийн 2021 оны 4 сарын 24-ний өдрийн  
Хувьцаа эзэмшигчдийн-ээлжийн хурлын  
01-р тогтолцоо УДИРДАХ хувьцаат компанийн  
ЗӨВЛӨЛ

ТТН2998-2076357

## ГОВЬ ХК-ИЙН -2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

Говь ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт, 2020 оны зорилтуудын талаарх илтгэлийг Компанийн тухай хууль, Говь ХК-ийн дүрмийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь тус компанийн 2020 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, компанийг удирдах үйл ажиллагаандаа Сайн засаглалын зарчмууд, Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдлөг болгож, Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр зөвлөмж, төлөвлөгөөт зорилтыг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж ирлээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан 2020 оны бизнес төлөвлөгөө нь компанийн нийт борлуулалтын орлогыг өмнөх оноос 27% өсгөх, нийт ажилтны тоог тогтвортой түвшинд байлгаж, шинээр Канад, Австрали, Япон, Орос, Энэтхэг болон Казакстаны зах зээлд нэвтэрч нийт 200 мяанган эцсийн бүтээгдэхүүнийг хилийн чанд дахь өөрийн дэлгүүр болон цахим борлуулалтын сувгаар борлуулах, Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO45001:2018 болон Байгаль орчны удирдлагын тогтолцоо ISO14001:2015 стандартын баталгаажуулалтуудыг авах, олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 стандартыг нэвтрүүлэх ажлыг дахин идэвхжүүлэхэд тус тус чиглэсэн билээ.

Говь ХК 2020 онд 117,1 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийж, бизнес төлөвлөгөөний биелэлт 44 хувийн гүйцэтгэлтэй гарлаа. Гадаад борлуулалт 2020 онд 36 тэрбум төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 30.8 хувь, дотоод борлуулалт 49.5 тэрбум төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 42.2 хувь, онлайн борлуулалт 31.6 тэр бум төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 27 хувьд хүрчээ.

Мөн тайлант жилд 655 тонн түүхий эд бэлтгэж, нийт 916.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 515.6 сая төгрөг буюу 56.3% нь тоног төхөөрөмж, барилга байгууламжийн тохижуулалтад, 271.4 сая буюу 29.6% нь компьютер болон программ хангамжид, 129 сая буюу 14.1% нь барааны тэмдэгт болон тавилга эд хогшилд тус тус зарцуулагдсан байна.

Иймд Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2020 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна.

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ